

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Мандал сум дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэлтэс-413 дугаар нээлттэй, хаалттай хорих ангийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2025/092-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn www.open.audit.mn Сүхбаатар сум 2025 он	Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 7036-3040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 7036-3036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn Аудитор: Б.Наранцэцэг Утас: 7036-2442 Цахим хаяг: Narantsetsegba@audit.gov.mn
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын дүгнэлт	3-4
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5-12
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	13-17
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	13
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	13-14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	14
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт	14-15
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	15-17
4. Аудитын тайлан	18-20
4.1 Ерөнхий зүйл	18
4.2 Материаллаг байдал	18
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	18-19
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	19
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	19-20
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	20
5. Аудитын илрүүлэлт	20-22
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	23-24

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НТШ	Нээлттэй тендер шалгаруулалт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТБОНӨХБАҮХАТ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай
ТББ	Төрийн бус байгууллага
ХӨТЯЭА	Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх алба
ХХК	Хязгаарлагдмал хувьцаат компани
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ХЗДХЯ	Хууль зүйн дотоод хэргийн яам
ШШГЕГ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар
ШШГХ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэлтэс

МАНДАЛ СУМ ДАХЬ ШҮҮХИЙН
ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ХЭЛТЭС-413
ДУГААР НЭЭЛТТЭЙ, ХААЛТТАЙ
ХОРИХ АНГИЙН ДАРГА, ДЭД ХУРАНДАА
Д.НАРАНБЯМБА ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Мандал сум дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэлтэс-413 дугаар нээлттэй, хаалттай хорих ангийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Мандал сум дахь ШШГХ-413 дугаар хорих ангийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан.

Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд тус анги нь хоригдлыг нийгэмд суллагдан гарахад бэлтгэх, нийгмийн харилцаанд ороход дэмжлэг үзүүлэх, амьдралын зөв дадал, харилцааны эерэг зан үйлийг төлөвшүүлэх зорилгоор “Хөршийн хайр” ТББ-аас өгсөн 47,203.8 мянган төгрөгийг нэмэлт санхүүжилтийн дансанд орлого авч, жилийн эцэст төсөвт төвлөрүүлэн авлагаар тайлагнасан байна.

Аудитын гол асуудал

Дээд шатны төсвийн захирагчаас тус газрын тайлант оны төсвийн төлөвлөлт, хуваарилалтыг тухайн сарын гүйцэтгэлд үндэслэн сар бүр өөрчилж, зохицуулалт

хийж байгаа буюу бодит гүйцэтгэлтэй уялдуулан өөрчилж байгаа нь төсвийн төлөвлөлтийг тооцоо, судалгаанд үндэслэн бодитоор төлөвлөдөггүй болохыг харуулж байна.

Бусад асуудлын хэсэг

Тус анги нь тайлант оны "Гүйцэтгэлийн төлөвлөгөө"-г 4 зорилтын хүрээнд 57 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, биелэлтийг 94.0 хувьтай тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ч.ЭНХТУЯА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/			
Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	458,892,900.08	497,490,663.86
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	14,376,143.54	24,220,774.09
31210	Төгрөг	14,376,143.54	24,220,774.09
31211	Төрийн сангийн харилцах	14,376,143.54	24,220,774.09
33	АВЛАГА	22,440,010.41	61,767,206.49
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	0.00	1,134,198.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	1,000,000.00	50,357,321.00
33500	Бусад авлага	21,440,010.41	10,275,687.49
33510	Байгууллагаас авах авлага	21,440,010.41	10,275,687.49
35	БАРАА МАТЕРИАЛ	422,076,746.13	411,502,683.28
35100	Түүхий эд материал	57,838,442.39	41,809,796.17
35110	Тусгай зориулалттай материал	54,527,537.39	39,590,870.36
35130	Эм боох материал	3,310,905.00	2,218,925.81
35200	Дуусаагүй үйлдвэрлэл	15,860,048.58	17,174,792.71
35300	Бэлэн бүтээгдэхүүн	83,719,804.06	124,177,271.19
35400	Хангамжийн материал	154,278,451.10	119,320,823.21
35410	Бичиг хэргийн материал	1,997,827.52	737,400.00
35420	Аж ахуйн материал	63,279,846.16	49,555,144.27
35430	Сэлбэг хэрэгсэл	7,149,300.00	6,588,500.00
35440	Түлш, шатах тослох материал	16,034.08	16,991,197.00
35450	Барилгын засварын материал	16,533,300.66	1,059,604.00
35460	Хүнсний материал	53,742,163.99	39,697,248.29
35470	Бусад хангамжийн материал	11,559,978.69	4,691,729.65
35600	Мал амьтад	110,380,000.00	109,020,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	11,103,768,677.25	11,337,853,480.67
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	11,103,768,677.25	11,337,853,480.67
39200	Биет хөрөнгө	2,701,506,677.21	2,935,591,480.67
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,856,302,084.76	2,959,504,953.44
39202	Хуримтлагдсан элэгдэл	-560,340,940.88	-648,015,444.57
39203	Авто-тээврийн хэрэгсэл	317,403,875.00	419,303,875.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-277,857,207.78	-259,862,208.33
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	635,460,981.87	642,916,007.53
39206	Хуримтлагдсан элэгдэл	-429,798,944.94	-362,979,400.40
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	57,523,250.00	82,937,250.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-36,033,451.11	-36,402,882.33
39211	Батлан хамгаалах, цэргийн зориулалттай тоног төхөөрөмж	28,170,620.00	28,170,620.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	17,252,000.00	17,252,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-9,349,999.80	-10,007,699.76
39216	Дуусаагүй барилга, байгууламж	102,774,410.09	102,774,410.09
39300	Биет бус хөрөнгө	8,402,262,000.04	8,402,262,000.00
39301	Програм хангамж	1,604,500.00	1,604,500.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,604,499.96	-1,604,500.00
39303	Бусад биет бус хөрөнгө	8,402,262,000.00	8,402,262,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	11,562,661,577.33	11,835,344,144.53
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	13,431,764.04	34,905,650.79
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	13,431,764.04	34,905,650.79
41300	Өглөг	13,431,764.04	34,905,650.79

41310	Ажилчидтай холбогдсон өглөг	62,752.33	10,399,215.59
41360	Бусад өглөг	13,369,011.71	24,506,435.20
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	13,369,011.71	24,506,435.20
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	11,549,229,813.29	11,800,438,493.74
51	Засгийн газрын хувь оролцоо	11,549,229,813.29	11,800,438,493.74
51100	Засгийн газрын оруулсан капитал	8,727,358,630.01	8,727,358,630.01
511001	Улсын төсвийн оруулсан хөрөнгө	8,727,358,630.01	8,727,358,630.01
51200	Хуримтлагдсан үр дүн	563,051,195.02	831,660,537.89
51210	Өмнөх үеийн үр дүн	742,234,183.19	580,451,857.44
51220	Тайлант үеийн үр дүн	-179,182,988.17	251,208,680.45
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,258,819,988.26	2,241,419,325.84
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	11,562,661,577.33	11,835,344,144.53

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

			/төгрөгөөр/	
Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН	
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	4,883,925,194.40	5,575,960,466.27	
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	516,838,294.40	811,426,045.27	
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	429,110,192.00	811,426,045.27	
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	394,007,192.00	324,145,881.03	
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	35,103,000.00	487,280,164.24	
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	87,728,102.40	0	
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	4,367,086,900.00	4,764,534,421.00	
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	4,364,086,900.00	4,680,330,600.00	
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	4,364,086,900.00	4,680,330,600.00	
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	3,000,000.00	84,203,821.00	
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	0.00	47,203,821.00	
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,000,000.00	0.00	
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	30,000,000.00	
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	0.00	7,000,000.00	
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	5,062,867,580.25	5,324,751,785.82	
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,062,867,580.25	5,324,751,785.82	
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,607,111,969.19	4,531,897,785.82	
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,153,525,489.13	3,022,066,817.59	
210101	Үндсэн цалин	1,318,676,445.27	1,682,187,802.00	
210102	Нэмэгдэл	779,253,302.96	1,304,879,015.59	
210103	Унаа хоолны хөнгөлөлт	49,504,823.00	0.00	
210104	Урамшуулал	6,090,917.90	35,000,000.00	
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	46,108,933.12	61,763,500.00	
210201	Тэтгэврийн даатгал	14,036,065.35	0.00	
210202	Тэтгэмжийн даатгал	255,824.30	0.00	
210203	ҮОМШӨ-ний даатгал	204,659.44	0.00	
210204	Ажилгүйдлийн даатгал	51,164.86	0.00	
210205	Эрүүл мэндийн даатгал	31,561,219.17	61,763,500.00	

2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	255,463,665.35	303,739,536.70
210301	Гэрэл, цахилгаан	138,688,721.99	149,024,195.25
210302	Түлш, халаалт	109,674,662.02	150,894,641.45
210303	Цэвэр, бохир ус	7,100,281.34	3,820,700.00
2104	Хангамж, бараа материалын зардал	272,776,245.29	277,595,742.28
210401	Бичиг хэрэг	6,404,330.00	11,375,446.18
210402	Тээвэр, шатахуун	37,827,788.20	50,383,840.83
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,858,539.60	6,442,100.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	250,000.00	518,900.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	16,985,374.33	31,184,541.85
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	179,984,949.84	136,461,256.14
210408	Бараа материал акталсны зардал	28,465,263.32	41,229,657.28
2105	Нормативт зардал	499,431,573.51	507,002,353.42
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	19,673,020.70	21,237,725.05
210502	Хоол, хүнс	393,681,478.20	444,461,406.79
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	86,077,074.61	41,303,221.58
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	88,172,818.00	89,238,324.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,603,600.00	1,309,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	79,000.00	0.00
210604	Урсгал засвар	86,490,218.00	87,929,324.00
2107	Томилолт, зочны зардал	445,400.00	500,000.00
210702	Дотоод албан томилолт	445,400.00	500,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	19,406,474.00	29,773,583.30
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	14,033,474.00	20,221,229.30
210804	Тээврийн хэрэгслийн татвар	400,000.00	1,325,200.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	80,000.00	410,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,893,000.00	2,545,754.00
210807	Газрын төлбөр		5,271,400.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	271,781,370.79	240,217,928.53
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	27,904,483.31	38,639,694.49
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	297,000.00	0.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	243,579,887.48	201,578,234.04
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,455,755,611.06	792,854,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,398,289,282.00	737,854,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	187,464,590.00	455,892,300.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	1,182,249,292.00	264,306,700.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	28,575,400.00	17,655,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,466,329.06	0.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,466,329.06	0.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	55,000,000.00	55,000,000.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	55,000,000.00	55,000,000.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	-178,942,385.85	251,208,680.45
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	240,602.32	0.00
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	240,602.32	0.00
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-179,182,988.17	251,208,680.45

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	4,845,844,767.93	5,293,368,579.60
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	471,894,967.93	525,721,658.60
120	Нийтлэг татварын бус орлого	471,894,967.93	525,721,658.60
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	455,696,667.93	510,810,251.54
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	118,466,700.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	455,696,667.93	392,343,551.54
120009	Бусад орлого	16,198,300.00	14,911,407.06
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	4,373,949,800.00	4,767,646,921.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	4,364,086,900.00	4,680,330,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	4,364,086,900.00	4,680,330,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	9,862,900.00	87,316,321.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	0.00	47,203,821.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,000,000.00	0.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	30,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	6,862,900.00	10,112,500.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,855,673,442.27	5,283,523,949.05
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,855,673,442.27	5,283,523,949.05
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,421,753,126.21	4,440,312,628.05
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,182,132,694.89	3,012,272,600.00
210101	Үндсэн цалин	1,342,923,625.13	1,683,322,000.00
210102	Нэмэгдэл	748,156,277.89	1,293,950,600.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	48,716,518.91	0.00
210104	Урамшуулал	42,336,272.96	35,000,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	36,863,355.07	61,763,500.00
210205	Эрүүл мэндийн даатгал	36,863,355.07	61,763,500.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	297,271,644.93	339,653,500.00
210301	Гэрэл, цахилгаан	168,143,344.93	176,252,500.00
210302	Түлш, халаалт	121,972,400.00	159,580,300.00
210303	Цэвэр, бохир ус	7,155,900.00	3,820,700.00
2104	Хангамж, бараа материалын зардал	112,610,825.57	152,066,900.00
210401	Бичиг хэрэг	3,345,800.00	9,642,700.00
210402	Тээвэр, шатахуун	104,420,025.57	130,232,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,504,000.00	6,442,100.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	250,000.00	518,900.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,091,000.00	5,230,600.00
2105	Нормативт зардал	373,849,845.00	452,760,700.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	13,270,100.00	20,060,700.00
210502	Хоол, хүнс	360,579,745.00	432,700,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	114,586,099.48	119,017,100.00

210601	Багаж, техник, хэрэгсэл	16,793,399.48	22,770,200.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,465,300.00	500,000.00
210604	Урсгал засвар	96,327,400.00	95,746,900.00
2107	Томилолт, зочны зардал	445,400.00	500,000.00
210702	Дотоод албан томилолт	445,400.00	500,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	189,398,672.27	212,125,628.05
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	182,994,676.27	200,226,028.05
210804	Тээврийн хэрэгслийн татвар	400,000.00	1,325,200.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	80,000.00	410,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,931,200.00	4,893,000.00
210807	Газрын төлбөр	992,796.00	5,271,400.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	114,594,589.00	90,152,700.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	113,642,989.00	90,152,700.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	951,600.00	0.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,433,920,316.06	843,211,321.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,395,430,482.00	737,854,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	187,464,590.00	455,892,300.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	1,182,249,292.00	264,306,700.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	25,716,600.00	17,655,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	844,984.30	0.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	844,984.30	0.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	37,644,849.76	105,357,321.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	37,644,849.76	105,357,321.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	-9,828,674.34	9,844,630.55
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	-9,828,674.34	9,844,630.55
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	24,204,817.88	14,376,143.54
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	14,376,143.54	24,220,774.09

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

					/төгрөгөөр/
Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	8,727,358,630.01	2,258,819,988.26	742,234,111.73	11,728,412,730.00
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	71.46	71.46
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	8,727,358,630.01	2,258,819,988.26	742,234,183.19	11,728,412,801.46
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
7	Өмчид гарсан өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
8	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00
9	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-179,182,988.17	-179,182,988.17
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	8,727,358,630.01	2,258,819,988.26	563,051,195.02	11,549,229,813.29
11	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	8,727,358,630.01	2,258,819,988.26	563,051,195.02	11,549,229,813.29
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	17,400,662.42	17,400,662.42
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	8,727,358,630.01	2,258,819,988.26	580,451,857.44	11,566,630,475.71
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	-17,400,662.42	0.00	-17,400,662.42
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
17	Өмчид гарсан өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
18	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00
19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	251,208,680.45	251,208,680.45
20	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	8,727,358,630.01	2,241,419,325.84	831,660,537.89	11,800,438,493.74

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,944,461,200.00	4,944,461,200.00	0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,944,461,200.00	4,944,461,200.00	0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,222,282,200.00	4,222,282,200.00	0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,012,272,600.00	3,012,272,600.00	0
210101	Үндсэн цалин	1,683,322,000.00	1,683,322,000.00	0
210102	Нэмэгдэл	1,293,950,600.00	1,293,950,600.00	0
210104	Урамшуулал	35,000,000.00	35,000,000.00	0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	61,763,500.00	61,763,500.00	0
210205	Эрүүл мэндийн даатгал	61,763,500.00	61,763,500.00	0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	339,653,500.00	339,653,500.00	0
210301	Гэрэл, цахилгаан	176,252,500.00	176,252,500.00	0
210302	Түлш, халаалт	159,580,300.00	159,580,300.00	0
210303	Цэвэр, бохир ус	3,820,700.00	3,820,700.00	0
2104	Хангамж, бараа материалын зардал	152,066,900.00	152,066,900.00	0
210401	Бичиг хэрэг	9,642,700.00	9,642,700.00	0
210402	Тээвэр, шатахуун	130,232,600.00	130,232,600.00	0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,442,100.00	6,442,100.00	0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	518,900.00	518,900.00	0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,230,600.00	5,230,600.00	0
2105	Нормативт зардал	452,760,700.00	452,760,700.00	0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	20,060,700.00	20,060,700.00	0
210502	Хоол, хүнс	432,700,000.00	432,700,000.00	0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	82,058,100.00	82,058,100.00	0
210601	Багаж, техник, хэрэгсэл	16,633,600.00	16,633,600.00	0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	500,000.00	500,000.00	0
210604	Урсгал засвар	64,924,500.00	64,924,500.00	0
2107	Томилолт, зочны зардал	500,000.00	500,000.00	0
210702	Дотоод албан томилолт	500,000.00	500,000.00	0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	31,054,200.00	31,054,200.00	0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	19,154,600.00	19,154,600.00	0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,325,200.00	1,325,200.00	0
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	410,000.00	410,000.00	0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,893,000.00	4,893,000.00	0
210807	Газрын төлбөр	5,271,400.00	5,271,400.00	0

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	90,152,700.00	90,152,700.00	0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	90,152,700.00	90,152,700.00	0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	722,179,000.00	722,179,000.00	0
2132	Бусад урсгал шилжүүлэг	722,179,000.00	722,179,000.00	0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	455,892,300.00	455,892,300.00	0
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	264,306,700.00	264,306,700.00	0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,980,000.00	1,980,000.00	0
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	4,944,461,200.00	4,944,461,200.00	0
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	4,680,330,600.00	4,680,330,600.00	0
310001	Улсын төсвөөс санхүүжих	4,680,330,600.00	4,680,330,600.00	0
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	264,130,600.00	264,130,600.00	0
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	118,466,700.00	118,466,700.00	0
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	145,663,900.00	145,663,900.00	0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	87,316,321.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	87,316,321.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	36,959,000.00
2106	Хангамж, бараа материалын зардал	36,959,000.00
210601	Багаж, техник хэрэгсэл	6,136,600.00
210604	Урсгал засвар	30,822,400.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	50,357,321.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	50,357,321.00
213503	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт,	50,357,321.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	87,316,321.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	87,316,321.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	47,203,821.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	30,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	10,112,500.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сэлэнгэ аймгийн Мандал сум дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэлтэс-413 дугаар нээлттэй, хаалттай хорих анги /цаашид Мандал сум дахь ШШГХ-413 дугаар хорих анги гэх/ нь *“Байгууллагын соёлыг төлөвшүүлж, ахлагчийн манлайллыг дэмжих”* жил болгон зарлаж, дэвшүүлсэн зорилтын хүрээнд дараах арга хэмжээг хэрэгжүүлэн ажилласан байна. Үүнд:

- Орчин үеийн удирдлагын шинэлэг арга барилыг үйл ажиллагаанд нэвтрүүлэх,
- Алба хаагчдын мэргэжлийн ур чадвар, ёс зүйг нэмэгдүүлж, соён гэгээрүүлэх,
- Ахлагчийн нийгмийн хамгааллыг бэхжүүлж, ажиллах орчин нөхцөлийг сайжруулах,
- Цэргийн албаны зохион байгуулалтыг жигдрүүлж, цэргийн хэргийн мэдлэгийг дээшлүүлэх гэх мэт.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- *Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,*
- *Нийгмийн даатгалын ерөнхий хуульд 2024 оны 06 дугаар сарын 05-нд,*
- *Хөдөлмөрийн тухай хуульд 2024 оны 01 дүгээр сарын 12, 06 дугаар сарын 05-нд,*
- *Төрийн хэмнэлтийн тухай хуульд 2024 оны 01 дүгээр сарын 17, 12 дугаар сарын 12-нд,*
- *Төрийн албаны тухай хуульд 2024 оны 05 дугаар сарын 16, 06 дугаар сарын 05-нд тус тус нэмэлт өөрчлөлт орсон,*
- *Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 128 дугаар тогтоолоор төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон гэх мэт.*

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

Мандал сум дахь ШШГХ-413 дугаар хорих ангийн санхүүгийн болон үйлдвэрлэлийн өдөр тутмын үйл ажиллагаанд зааварчилгаа өгөх, 2023 оны санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийн мөрөөр хийж хэрэгжүүлсэн арга хэмжээтэй танилцах удирдамжийн дагуу дээд шатны төсвийн захирагчийн зүгээс дотоод хяналт тавьж, зөвлөмж өгч ажилласан байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Мандал сум дахь ШШГХ-413 дугаар хорих ангийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус анги нь ШШГЕГ-ын даргын 2020 оны А/134 дүгээр тушаалаар баталсан "Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийг нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн бөгөөд тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Мандал сум дахь ШШГХ-413 дугаар хорих ангийн 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 272,682.57 мянган төгрөгөөр буюу 2.3 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	14,376.14	24,220.77	9,844.63
Авлага	22,440.00	61,767.21	39,327.21
Бараа материал	422,076.76	411,502.68	-10,574.08
Үндсэн хөрөнгө	11,103,768.67	11,337,853.48	234,084.81
Нийт хөрөнгө	11,562,661.57	11,835,344.14	272,682.57
Өр төлбөр	13,431.76	34,905.65	21,473.89
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	11,549,229.81	11,800,438.49	251,208.68
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	11,562,661.57	11,835,344.14	272,682.57

Дээрх хүснэгтээс харахад дараах дансанд нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна. Үүнд:

- Авлагын дансны үлдэгдэл 39.327.2 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь төсвийн зарцуулагдаагүй үлдэгдэл болон хандивын орлогын нийт 56,357.3 мянган төгрөгийг нэмэлт санхүүжилтийн данснаас төвлөрүүлж, татаас санхүүжилтийн авлагаар бүртгэсэн,
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 11,337,853.5 мянган төгрөг болж, 234,084.8 мянган төгрөгөөр өссөн нь ХЗДХЯ-аас 122,950.7 мянган төгрөгийн өртөг бүхий хорих ангийн барилгын их засвар, 128,400.0 мянган төгрөгийн өртөг бүхий 2 ширхэг авто тээврийн хэрэгсэл, ШШГЕГ-аас 34,324.9 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, ХӨТЯНА-аас 20,277.5 мянган төгрөгийн тавилга, эд хогшлыг тус тус үнэ төлбөргүйгээр шилжүүлсэн,
- Өр төлбөр дансны үлдэгдэл 34,905.6 мянган төгрөг болж 21,473.9 мянган төгрөгөөр өссөн нь ХХОАТ-ын 10,399.2 мянган төгрөгийн, шүүхийн шийдвэрийн 529.2 мянган төгрөгийн өр төлбөрийг төлж барагдуулаагүй зэргээс голлон шалтгаалжээ.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус ангийн 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 3,762,340.9 мянган төгрөг, үйл ажиллагааны орлогоос 372,349.8 мянган төгрөг, нийт зарлагыг **4,134,690.7** мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас нийт 216,860.3 мянган төгрөгөөр бууруулж **3,917,830.4** мянган төгрөгөөр баталсан байна. Үүнд:

- ✓ Цалин нэмэгдэл хөлс, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардлыг 903,004.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн бол
- ✓ Байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 128,132.2 мянган төгрөгөөр,
- ✓ Нэг удаагийн тэтгэвэр, тэтгэмжийн 17,523.0 мянган төгрөгөөр,
- ✓ Нормативт зардлыг 354,194.6 мянган төгрөгөөр,
- ✓ Эд хогшил, урсгал засварын зардлыг 243,186.0 мянган төгрөгөөр тус тус бууруулан баталсан нь голлон нөлөөлсөн байна.

Тайлант оны дундуур батлагдсан төсвийг нийт 1,026,630.8 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, **4,944,461.2** мянган төгрөгөөр эцэслэн баталсан байна. Үүнд:

- Цалин, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардлыг 265,724.8 мянган төгрөгөөр,
- Байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 46,053.5 мянган төгрөгөөр,
- Урсгал шилжүүлгийн 720,199.0 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлсэн нь голлон нөлөөлсөн байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 4,680,330.6 мянган төгрөгийг улсын төсвөөс, 264,130.6 мянган төгрөгийг туслах үйл ажиллагааны орлогоос бүрдүүлэхээр төлөвлөн, гүйцэтгэлээр улсын төсвөөс 4,680,330.6 мянган төгрөгийн санхүүжилт авч, үйл ажиллагааны орлогоос 264,130.6 мянган төгрөг төвлөрүүлсэн байна.

Туслах үйл ажиллагаанаас нийт 319,130.6 мянган төгрөг төвлөрснөөс үндсэн үйл ажиллагаанд 264,130.6 мянган төгрөгийг зарцуулж, 55,000.0 мянган төгрөгийг ШШГЕГ-т төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 4,944,461.2 мянган төгрөг буюу 100.0 хувьтай тайлагнагдсан байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Үндсэн үйл ажиллагааны зардал	4,072,766.00	4,072,766.00	0.00	100
2	Туслах үйл ажиллагааны зардал	145,663.90	145,663.90	0.00	100
3	Шийдвэр гүйцэтгэлийн үйлчилгээ	3,852.30	3,852.30	0.00	100
4	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал	722,179.00	722,179.00	0.00	100
	Нийт	4,944,461.2	4,944,461.2	0.00	100

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

ШШГЕГ-аас урсгал засварын зардалд 30,000.0 мянган төгрөг, төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 10,112.5 мянган төгрөг, төрийн бус байгууллагаас 47,203.8 мянган төгрөгийн хандив зэрэг нийт 87,316.3 мянган төгрөгийн орлого төвлөрч, тус ангийн засвар, багаж техник хэрэгслийн зардалд 29,959.0 мянган төгрөгийг зориулалтын дагуу зарцуулж, үлдэгдэл 50,357.3 мянган төгрөгийг төсөвт татан төвлөрүүлж, татаас санхүүжилтийн авлагаар бүртгэсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.3 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд дараах худалдан авах ажиллагааны урилгыг ТБОНӨХБАҮХАТ хуульд заасны дагуу tender.gov.mn-д цахим сайтад байршуулж, зохион байгуулсан байна. Үүнд:

/ мянган төгрөгөөр /

№	Тухайн жилд худалдан авах бараа, ажил, үйлчилгээний нэр төрөл, тоо, хэмжээ, хүчин чадал	Батлагдсан төсөв	Гэрээний дүн	Худалдан авах ажиллагаанд мөрдөх журам / Тендер шалгаруулалтын арга
1	Хүнсний материал /Гурил, будаа-95,300.0 мянган төгрөг /	471,000.0	471,000.0	НТШ
2	Хүнсний материал /Мах-250,000.0 мянган төгрөг/			
3	Хүнсний материал /Хуурай хүнс-127,700.0 мянган төгрөг/			
4	Нүүрс	122,500.0	122,499.5	НТШ
5	Шатахуун, шатах тослох материал	160,709.3	153,953.8	НТШ
	Нийт дүн			

Хүнсний материал бэлтгэн нийлүүлэгчийг сонгон шалгаруулах нээлттэй тендерийг 6 удаа зохион байгуулсан боловч оролцогч ирээгүй байна. Иймд Хараамонгилмаа ХХК-тай /200,000.0 мянган төгрөгийн/ мах, махан бүтээгдэхүүн нийлүүлэх, Ноцох дөл ХХК-тай /271,000.0 мянган төгрөгийн/ гурил, будаа, хүнс, хангамжийн материал нийлүүлэх гэрээг тус тус байгуулан, худалдан авалтыг гүйцэтгэсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Мандал сум дахь ШШГХ-413 дугаар хорих ангийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн хөрөнгийн бүртгэл, Ахмадын сан, ХХОАТ-ын тооцоололтой холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Наранцэцэг гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Мандал сум дахь ШШГХ-413 дугаар хорих ангийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 01/232 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 5,062,867.6 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 50,628.8 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотойгоор дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэн ажилласан байна. Үүнд:

- Тус байгууллагын үндсэн хөрөнгийн дансанд 18 тээврийн хэрэгсэл бүртгэлтэйгээс хөдөө аж ахуйд ашиглагддаг трактор, комбайн, бага оврын трактор, капатель, чиргүүл зэрэг тээврийн хэрэгслээс бусад автомашин нь бусад автотээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар ашиглаж байна,
- Бичгийн цаас, принтерийн хорны зардлыг хэмнэх зорилгоор бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтөд дотоод сүлжээг ашигласан,
- Үйл ажиллагаатай холбоотой сурталчилгаа, кино контент, тэмдэглэлт ой, баяр ёслолын арга хэмжээг зохион байгуулаагүй, төсвийн хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдаж аваагүй,
- Гар утасны зардал гаргаагүй,
- Хэвлэл захиалга хийлгээгүй зэрэг төсвийн шууд захирагчтай хамааралтай заалтуудыг мөрдөж, батлагдсан төсвийн хүрээнд ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Мандал сум дахь ШШГХ-413 дугаар хорих анги нь мэдээлбэл зохих 28 төрлийн 171 мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тайлант онд бусад хууль, тогтоомжийн хэрэгжилтэд хамаарах алдаа, зөрчил илрээгүй.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын 2024 оны 12 дугаар сарын 02-ны 173 дугаар “Санхүүгийн тайланд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар анхан шатны баримттай холбоотой дараах алдааг залруулсан. Үүнд:

- ✓ Малын зүй бус хорогдлын устгалын акт, өмч хамгаалах зөвлөлийн хурлын шийдвэрийг нэмж бүрдүүлсэн,
- ✓ Жолоочийн шатахууны тооцооны хуудсанд нягтлан бодогч болон тухайн автомашиныг ашигласан албан хаагчийн гарын үсгийн бүрдэл дутуу буюу бүрдэл дутуу анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлсэн,
- ✓ Аж ахуйн материал болон хатуу түлшний бараа материалын шаардах хуудсыг нөхөн хавсаргасан,
- ✓ Тайлант онд цэргийн албан хаагчдад олгосон хүнсний хангалтын хүлээн авсан анхан шатны баримтыг гүйцээн бүрдүүлсэн зэрэг.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар авлага үүсгэсэн, орлогын төлөвлөгөө тасалсан зэрэг 18,869.8 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлэн, төсвийг үнэн зөв төлөвлөөгүй 27,036.3 мянган төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж өгөгдсөнөөс биелэлтийг аудитаар дахин хянахад 75.0 хувийн хэрэгжилттэй байна.

Хүснэгт 4. Албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	2	18,869.8	2	18,869.8	100.0
Зөвлөмж	2	27,036.3	1	15,198.3	50.0
Нийт дүн	4	45,906.1	3	34,068.1	75.0

Тус анги нь өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр буюу төсвийн төлөвлөгөөг бодит тооцоо судалгаанд үндэслэн, эдийн засгийн ангиллаар үнэн зөв төлөвлөөгүй, төсвийн зохицуулалт хийх саналыг тухай бүр хүргүүлээгүйгээс зардлын бүлэг хооронд гүйлгэн зарцуулж, гүйцэтгэлийг бодитоор тайлагнаагүй зөрчлийг тайлант онд давтан гаргасан байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

1. Мандал сум дахь ШШГХ-413 дугаар хорих ангийн төсвийн шууд захирагчийн бус дээд шатны төсвийн захирагчийн шийдвэрээр хэрэгжсэн дараах асуудлыг дээд шатны төсвийн захирагчийн санхүүгийн тайланд хийх аудитын анхааралд хандуулж байна. Үүнд:

- ШШГЕГ-ын 2024 оны 06/1193 дугаар албан бичгийн дагуу хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажиллахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжийн зардлаас **17,055.2** мянган төгрөгийн ХХОАТ суутгасан байна.

2. Дараагийн аудитаар дараах асуудлуудад анхаарал хандуулж, авч үзэх шаардлагатай юм. Үүнд:

- Тус анги нь “Сод монгол груп” ХХК-тай 2024 оны 03 дугаар сарын 29-ний өдөр байгуулсан шатахуун худалдан авах СЭАМСШШГА/20240102006 тоот гэрээний 3-д “шатахууны цэвэр борлуулалтын дүнгээс 3 хувийн хөнгөлөлт үзүүлж, улирал бүр урамшуулал тооцож олгоно” гэж заасан заалтыг хэрэгжүүлж, гэрээний хэрэгжилтийг дүгнээгүйгээс худалдан авсан шатахууны үнийн хөнгөлөлт, урамшуулал эдлэх боломжийг алдсан байна. Иймд дээрх байгууллагатай гэрээний биелэлтийг дүгнэж, шатахууны урамшууллыг эдэлсэн эсэх асуудлыг дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй юм.
- Тайлант оны эцэст түлш, шатах тослох материал, хүнсний материал, тусгай зориулалтын материал, аж ахуйн материал, бэлэн бүтээгдэхүүн зэрэг бараа материал 16,991.2-124,177.3 мянган төгрөгийн буюу ихээхэн хэмжээний үлдэгдэлтэй тайлагнагдсан бөгөөд эдгээр бараа материалын үлдэгдлийн хадгалалт, хамгаалалт, зарцуулалтыг дараагийн аудитаар авч үзэх шаардлагатай юм.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Залруулсан алдаа:

Аудитын явцад бараа материалын тайлангаар хасах үлдэгдэлтэй тайлагнасан хөрөнгийн өртгийг залруулав.

Аудитаар нийт **24,811.0** мянган төгрөгийн зөрчил¹ илэрч 1 албан шаардлага хүргүүлэн, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 зөвлөмж хүргүүллээ.

5.1 Албан шаардлага

5.1.1. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр нийт **24,811.0** мянган төгрөгийг зардлын эдийн засгийн ангилал хооронд гүйлгэн зориулалт бусаар зарцуулж, гүйцэтгэлийг бодитоор тайлагнаагүй байна. Үүнд:

- ✓ Хоол, хүнсний зардлаас дотоод үйл ажиллагаанд зориулагдсан цай, кофе, ус, ундаа болон бусад бага үнэтэй түргэн элэгдэх зүйл худалдан

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

авахад **2,878.9** мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд *Иногооны үрийн* **21,932.1** мянган төгрөг гэх мэт.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “*Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах*”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан гаргах үндэслэл болно*”, Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан “*Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар*”-ыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэлт: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1 дэх “*Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана*”, 4.2.1.10: “*Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол*” гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

5.2.1. Үндсэн хөрөнгийн бүртгэлтэй холбоотой асуудал:

Илрүүлэлт: Өмнөх онуудад хэрэгжиж дууссан хүлэмж, гүний худаг, ногооны зоорь зэрэг хөрөнгүүдийг бүртгэлд авах зөвшөөрлийг холбогдох байгууллагуудаас ирүүлээгүй гэх үндэслэлээр дуусаагүй барилга дансанд бүртгэж, тайлагнасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх “... хөрөнгө, эх үүсвэрийн **хөдлөл, өөрчлөлт** бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Дээрх хөрөнгүүдийг орлого авч, 2025 оны эхний хагас жилийн тайланд барилга, байгууламж дансанд бүртгэж, тайлагнах.

5.2.2. Төсвийн төлөвлөлттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7 дахь “... байгууллага өөрийн төсөв, үйл ажиллагааны орлогоосоо цалингийн нийт сангийн гурав хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр “Ахмадын сан” байгуулах ...”, Засгийн газрын 2017 оны 197 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Ахмадын сан байгуулан ажиллуулах журам”-ын 1.3 дахь “*Төсөвт байгууллагын тухайд цалингийн сангийн 3 хүртэлх хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр сан байгуулж, шаардагдах хөрөнгийг төсөвтөө жил бүр тусгана*” гэсэн заалтыг хэрэгжүүлж, зайлшгүй гарах зардлыг төсвийн төлөвлөгөөнд тусган батлуулаагүйгээс цалин хөлс, урамшууллын батлагдсан төсвөөс “Ахмадын сан”-г санхүүжүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх "Төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад дараах зарчмыг баримтална", 5.1.2: Төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх", 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7 дахь заалтыг хэрэгжүүлэн тухайн жилийн төсвийн төлөвлөгөөнд "Ахмадын сан"-ийн зардлыг тусган, батлуулах.

5.2.3. ХХОАТ-ын тооцоололтой холбоотой асуудал:

Илрүүлэлт: Тайлант оны эцэст цалингийн бодолтод татварын хөнгөлөлтийн тооцооллыг хийгээгүй байгаа нь ХХОАТ-ын өр, авлага үүсэх эрсдэлийг үүсгэж байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасныг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Татварын хөнгөлөлтийн тооцооллыг тооцож, зөрүү үүссэн тохиолдолд 2025 оны эхний хагас жилийн тайланд залруулах.

Дээрх зөвлөмжүүдийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20.5² дахь заалтад тусгасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2025 оны 07 дүгээр сарын 30-ны өдрийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

² Шалгаагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	/мянган төгрөгөөр/											
	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Залруулсан		Залруулаагүй		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бараа материалын өртөг буруу бүртгэсэн	1				1				1			
Дүн	1				1				1			

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	/мянган төгрөгөөр/											
	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаа	Тоо	Дүн
Батлагдсан төсвийг зориулалт бусаар зарцуулсан	1	24,811.0			1	24,811.0						
Ахмадын санг төсөвт тусгаж, батлаагүй	1						1					
Хэрэгжиж дууссан хөрөнгүүдийг дуусаагүй барилга дансанд бүртгэсэн	1						1					
Жилийн эцэст ХХОАТ-ын хөнгөлөлтийн тооцоог хийж, баталгаажуулаагүй	1						1					
Дүн	4	24,811.0			1	24,811.0	3					

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	/мянган төгрөгөөр/					
	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн